

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо /цаашид "Дэд хороо" гэх/ нь Улсын Их Хурлын гишүүдээс ёс зүйн шаардлагуудыг сахин биелүүлэхэд туслалцаа үзүүлэх, тэдний ёс зүйн байдалд хяналт тавих, эрхлэх асуудлынхаа хүрээнд асуудал боловсруулах, санал, дүгнэлт гаргах, хянан шалгах, түүнийгээ харьяалах Байнгын хороо буюу Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оруулах эрх бүхий Улсын Их Хурлын байгууллага байна.

2. Дэд хороо нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэ дүрмийг мөрдлөг болгоно.

Хоёр. Дэд хорооны бүрэн эрх

3. Дэд хороо нь өөрийн эрхлэх асуудлаараа дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 1/ асуудал боловсруулах, санал, дүгнэлт гаргах, түүнийгээ харьяалах Байнгын хороо буюу Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оруулах;
 - 2/ өөрийн эрхэлсэн асуудлаараа хянан шалгах, судалгаа хийх, ажлын хэсэг байгуулах;
 - 3/ холбогдох мэдээллийн талаар иргэн, байгууллага, албан тушаалтнаас тайлбар, тодруулга авах;
 - 4/ холбогдох байгууллага, мэргэжлийн хүнийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах;
 - 5/ шаардлагатай тохиолдолд Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн зөрчлийн асуудлыг өөрийн санаачилгаар шалган тодруулах, эсхүл холбогдох байгууллагад шилжүүлэх;
4. Дэд хороо нь дараахь үйл ажиллагаатай холбогдсон Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн асуудлыг дагнан хариуцна:
- 1/албаны үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн хэм хэмжээ;
 - 2/ албан тушаал хашихтай холбогдсон ёс зүйн хэм хэмжээ;
 - 3/ орлого, томилоттой холбогдсон ёс зүйн хэм хэмжээ;
 - 4/ шагнал, бэлэг дурсгалын зүйлийг хүлээн авахтай холбогдсон ёс зүйн хэм хэмжээ;
 - 5/сонгуулийн компани ажлын үеэр баримтлах ёс зүйн хэм хэмжээ.

Гурав. Дэд хороо, түүний гишүүдийн үүрэг

5. Дэд хороо нь Улсын Их Хурлын гишүүнээс хууль зөрчсөн аливаа үйлдэл, эс үйлдэл гаргахаас урьдчилан сэргийлж, үйл ажиллагаандаа баримталбал зохих хууль тогтоомжийн талаар зөвлөгөө өгөх, мэдээллээр хангахад туслалцаа үзүүлэх, ёс зүйн зөрчлийн асуудлыг магадлан тодруулах, нэр төрийг нь хамгаалах, эрхлэх асуудлаараа хянан шалгах бүрэн эрхтэй.
- 6.Дэд хорооны гишүүн нь хуралдааныг үл хүндэтгэн хуралдааны ирцийг тасалдуулах, оролцохгүй байх, хуралдааныг орхиж гарахыг хориглоно.

Дөрөв. Дэд хорооны бүтэц, зохион байгуулалт

7. Дэд хороо нь 8-аас илүүгүй гишүүнтэй байх бөгөөд олонхи, цөөнхийн төлөөлөл тэнцүү байна. Цөөнхийн гишүүд хэтэрхий цөөнх байвал дэд хорооны гишүүн байж болох цөөнхийн гишүүний тоотой тэнцүү төлөөлөлтэй байхаар хуваарилж болно.
- 8 Дэд хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан мөн. Дэд хорооны дарга нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тогтоож, зарлан хуралдуулна.
- 9.Хуралдааныг Дэд хорооны гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцно.
10. Улсын Их Хурлын гишүүнд холбогдох ёс зүйн асуудлыг Дэд хорооны хаалттай хуралдаанаар хэлэлцэж, гишүүдийн дийлэнхи олонхийн саналаар шийдвэрлэх бөгөөд гаргасан дүгнэлт, шийдвэр нь олон нийтэд ил тод, нээлттэй байна.
11. Хуралдаанд зөвхөн Дэд хорооны гишүүд таслах эрхтэй бусад гишүүн таслах эрхгүйгээр оролцоно. Улсын Их Хурлын гишүүнд холбогдох ёс зүйн асуудлыг хэлэлцэх хаалттай хуралдаанд зөвхөн Дэд хорооны гишүүд оролцоно.

Тав. Дэд хорооны үйл ажиллагааны журам

12. Дэд хороо дараахь тохиолдолд Улсын Их Хурлын гишүүнд холбогдох ёс зүйн зөрчлийн асуудлыг авч хэлэлцэнэ:

- 1/ ёс зүйн зөрчлийн талаар иргэн, байгууллагаас өргөдөл, гомдол, мэдээлэл ирүүлсэн;
- 2/ Улсын Их Хурлын 8-аас доошгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүнд холбогдох ёс зүйн зөрчлийн талаар өргөдөл, гомдол, мэдээлэл ирүүлсэн;
- 3/ ёс зүйн хувьд нэр төрд харшилсан гэж үзэж Улсын Их Хурлын гишүүн өөрөө санал гаргасан;

13. Ёс зүйн зөрчилд холбогдсон Улсын Их Хурлын тухайн гишүүн уг өргөдөл, гомдол, мэдээлэлтэй бүрэн танилцах, холбогдох асуудлаар тайлбар, баримтыг гаргаж өгөх, хуралдаанд биеэр оролцох эрхтэй.

14. Дэд хорооны гишүүдийн олонхийн саналаар өргөдөл, гомдол, мэдээлэл ирүүлсэн иргэн, байгууллагын төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүд гомдол гаргасан бол тэдгээр гишүүд буюу төлөөлөгчийг хуралдаанд байлцуулж болно.

15. Дэд хороонд ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээлэл нь бичгээр үйлдэгдсэн, он, сар, өдөртэй, холбогдох нотолгоо, баримтыг хавсаргасан байх бөгөөд дараахь зүйлсийг тусгасан байна:

- 1/ өргөдөл, гомдол гаргагчийн овог, нэр, албан ёсны хаяг;
- 2/ ёс зүйн зөрчил гаргагчийн овог, нэр, албан тушаал;
- 3/ уг өргөдөл, гомдолд албан үүргээ биелүүлэхдээ ёс зүйн ямар асуудлаар, холбогдох хууль, тогтоомж, дүрмийг хэрхэн зөрчсөн тухай үндэслэл;
- 4/ зөрчлийг нотлох, тодруулах баримт.

16. Дэд хороо өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор уг өргөдөл, гомдол ирсэн тухай Улсын Их Хурлын холбогдох гишүүнд танилцуулах бөгөөд 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хуульд заасан журмын дагуу энэ хугацааг сунгаж болно.

17. Ёс зүйн зөрчилд холбогдсон Улсын Их Хурлын гишүүн Дэд хорооноос ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор өөрийн тайлбар баримтыг гаргаж өгнө.

18. Дэд хороонд ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэлд дурдсан асуудлыг хуулийн байгууллага, эрх бүхий албан тушаалтан шалгаж байгаа бол тухайн асуудлыг хойшлуулна.

19. Дэд хороо нь аливаа асуудлыг улс төржүүлэхгүй байх, улс төрийн аль нэг нам, эвслийн бүлгийн ашиг сонирхолд автахгүй байх, асуудалд бодит байдал, итгэл үнэмшилтэй, шударга хандана.

20. Дэд хороо нь энэ дүрмийн 4-т заасан ёс зүйн зөрчлийн асуудлыг хуралдаанаараа хэлэлцэнэ. Хуралдааныг дараахь дарааллаар явуулна:

- 1/ хуралдаан даргалагч хэлэлцэх асуудлыг танилцуулж хуралдааныг удирдан явуулна;
- 2/ албан тушаалтанд холбогдсон ёс зүйн зөрчлийн талаар танилцуулна;
- 3/ тухайн асуудлыг шалган тодруулсан бол дүнг танилцуулна;
- 4/ гишүүд асуулт асууж, хариулт авч болно;
- 5/ тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэх, ногдуулах хариуцлагын талаар гишүүд санал, дүгнэлт гаргана.
- 6/ тухайн асуудлаар гарах шийдвэрийн талаар ил санал хураалт явуулна. Хэрэв санал тэнцвэл дахин санал хураана. Санал дахин тэнцвэл Дэд хорооны даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

21. Хуралдааны явцын тэмдэглэлийг гараар болон соронзон хальсанд нэгэн зэрэг бичнэ.

Хуралдааны явцын тэмдэглэлд дараахь бичиг баримтыг заавал хавсаргана:

- 1/ тухайн өдрийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлын төлөвлөгөө, байлцсан хүмүүсийн нэр, албан тушаал;
- 2/ хуралдаанаар хэлэлцсэн асуудалтай холбогдуулан ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, нотлох, тодруулах болон бусад баримт бичиг;
- 3/ хэлэлцсэн асуудалтай холбогдуулан гаргасан Дэд хорооны санал, дүгнэлт.

22. Дэд хорооны хаалттай хуралдааны явцын тэмдэглэлийг Тамгын газрын нууцын асуудал эрхэлсэн ажилтан хөтлөх бөгөөд холбогдох бусад баримт бичгийн хамт зөвхөн Ёс зүйн дэд хороонд хадгална.

23. Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшсэн Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн асуудалтай холбогдуулан гаргасан гомдлыг Сонгуулийн ерөнхий хороонд гаргана.

Зургаа. Хариуцлага ногдуулах

24. Дэд хороо нь Улсын Их Хурлын гишүүнд холбогдох ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх тухай асуудлыг хуралдаанаараа хэлэлцээд өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргах буюу санал дүгнэлтээ харьяалагдах Байнгын хороо буюу Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оруулна.

25. Дэд хороо нь гишүүнд холбогдох ёс зүйн зөрчлийн шинж байдал, үр дагавар, хор уршиг, анх буюу давтан үйлдсэн зэргийг харгалзан хариуцлага хүлээлгэнэ.

26. Зөрчилд холбогдсон гишүүнд зөвлөмж гаргах, буруушаасан захидал илгээх арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн бол Дэд хороо тогтоол гаргана.

27. Дараахь арга хэмжээ оногдуулахаар бол энэ тухай санал дүгнэлтээ харьяалах Байнгын хороонд оруулна:

1/ сануулах;

2/ донгодох;

3/ сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах.

28. Харьяалах Байнгын хороо Дэд хорооны санал, дүгнэлтийг "Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг"-д заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

29. Улсын Их Хурлын гишүүнд холбогдох ёс зүйн зөрчил нь тухайн гишүүнийг огцрохыг шаардах үндэслэл байна гэж үзвэл уг асуудлыг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оруулна.

30. Улсын Их Хурлын гишүүн нь холбогдох хууль тогтоомж зөрчин бусдаас бэлэг, урамшуулал, шан харамж авсан, томилолт, аялалын зардлаа төлүүлсэн, тусгай эрх, хөнгөлөлт эдэлсэн нь нотлогдсон бол Дэд хороо тэдгээрийг буцаалгах буюу хуульд заасан журмын дагуу үнэ өртгийг нь нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.

31. Улсын Их Хурлын гишүүнд холбогдох ёс зүйн зөрчлийн асуудлыг дахин хэлэлцүүлэхээр Дэд хороонд ирүүлсэн тохиолдолд уг асуудлаар дахин хуралдаж өмнөх шийдвэрээ хэвээр үлдээх, эсхүл нэг удаа өөрчилж болно.

32. Улсын Их Хурлын гишүүн ёс зүйн зөрчил гаргаагүй нь нотлогдвол Дэд хороо энэ тухай дүгнэлт гаргах бөгөөд дүгнэлтийнхээ үндэслэлийг гомдол, мэдээлэл гаргагчид болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр албан ёсоор мэдээлнэ.

33. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, Засгийн газрын гишүүд болон Улсын Их Хурлаас байгуулагддаг байгууллагын дарга нарт холбогдох ёс зүйн зөрчлийн асуудлыг хэлэлцэхэд энэ журмыг баримтална